



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 1/106

Халбан

**Малын гоц халдварт шүлхий өвчний  
дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай.**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дүгээр зүйлийн 66.1. заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 225-р тогтоолын 1-р хавсралт, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 07 сарын 31 -ны өдрийн А/394 тоот захирамж, Хөвсгөл аймгийн МЭГ-ын даргын 2024 оны 08 дүгээр сарын 1-ны өдрийн А/35 тоот тушаал зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтанд бүх үхэр сүргийг 2024 оны 08 дугаар сарын 05 -ны өдрөөс 2024 оны 09 дүгээр сарын 05 -ны өдрүүдэд хамруулж дуусгахыг "Баялаг үйл – Ундрах" мал эмнэлгийн эзэн, малын эмч М.Баатаржав, "Таг дүүрэн сүрэг" мал эмнэлгийн захирал, малын эмч Н.Доржжүгдэр, бусад малын эмч мэргэжилтнүүд, багийн засаг дарга нарт даалгасугай.

2. Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дархлаажуулалтын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж эмч, мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч - /Н.Алтанхуяг/-д үүрэг болгосугай.

4. Малчдыг тогтоосон хугацаанд нэг цэгт малаа бэлэн байлгах, хүн хүчний нөөцийг бүрдүүлэх, зарлан мэдээлэл хүргэх зэрэг шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг бүх багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын тамгийн газрын дарга - /Б.Бямбажав/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.АНХБАЯР



Цэцэрлэг сумын Засаг даргын 2024 оны  
08 дугаар сарын 20-ны өдрийн А/  
тоот захирамжийн 1 дүгээр хавсралт

Шүлхий өвчний дархлаажуулалтанд хамрагдах үхрийн тоо ,вакцины  
хуваарь.

2024.08.05.

Дэс.	Багийн нэр.	МЭҮН-ийн нэр.	Хамрагдах өрхийн тоо	Вакцинд хамрагдах үхрийн тоо /толгой /	Олгох вакцин /тун/
1	Дэлгэрхаан.	Таг дүүрэн сүрэг	147	4073	4073
2	Ренчинжугнай		141	3840	3840
3	Уранхайрхан		199	5848	5848
4	Жаргалант		137	3439	3439
<b>Дүн-1</b>			<b>624</b>	<b>17200</b>	<b>17200</b>
5	Зуунмод	Баялаг үйл-Ундрах	197	6124	6124
6	Халбан		82	1224	1224
7	Бүрхээр		63	1652	1652
<b>Дүн-2</b>			<b>342</b>	<b>9000</b>	<b>9000</b>
<b>Сумын дүн</b>			<b>966</b>	<b>26200</b>	<b>26200</b>

Боловсруулсан: Цэцэрлэг сумын МЭТ-ийн дарга, мал эмнэлгийн  
хяналтын улсын байцаагч  
Н.Алтанхуяг